Эм зүйч мэргэжилтэн бэлтгэх сургалтын нэгж хичээлийн хөтөлбөрийн үнэлгээ

Б.Билгүүн[1], Д.Шинэзаяа[1], Б.Оюунгоо[2], З.Анхзаяа[3], Д.Даваадагва[1]

[1]АШУҮИС, ЭЗС, Эмийн технологийн тэнхим
[2]АШУҮИС, Сувилахуйн сургууль
[3]ТТАХНЭ
Цахим шуудан: Bilguun.ba@mnums.edu.mn, Утас: 99804015

Түлхүүр үг:

Хөтөлбөр
Хичээлийн сэдэв
Матриц
Эм зүйч

Товч утга:

Үндэслэл: Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн буюу хөтөлбөрөөр суралцаж төгсөх оюутны эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг сургалтын төлөвлөгөөнд байгаа ямар ямар хичээлийг судалснаар оюутанд эзэмших боломжтойг харуулсан хичээл ба суралцахуйн үр дүн хоорондын хамаарлын матрицыг тодорхойлох нь бидний судалгааны ажлын үндэслэл болсон. **Зорилго:** "Эм зүйч" мэргэжилтэн бэлтгэх нэгж хичээлийн агуулгыг (TLO) хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй (PLO) уялдуулан үнэлэх. **Арга, аргачлал:** Бид Аналитик судалгааны загвараар баримтын судалгаанд үндэслэн сургалтын хөтөлбөрийн агуулга болон хүрэх үр дүнг судалсан. **Үр дүн:** "Эм зүйч" мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн үр дүнг (PLO) зарим хичээлийн хүрэх үр дүнтэй (CLO) уялдуулан судлахад эм зүйч мэргэжлийн "Тусламж үзүүлэгч" (PLO 1), Зохион байгуулагч (PLO 4), Тасралтгүй суралцагч (PLO 6), Мэргэжилтэн (PLO 7) гэсэн чадамжтай тухайн хичээлийн K1,K2,K3,K4 мэдлэгүүд сул хамааралтай. "Тусламж үзүүлэгч" (PLO 1), Харилцагч (PLO 2), Хамтрагч (PLO 3), Тасралтгүй суралцагч (PLO 6) гэсэн чадамжтай тухайн хичээлийн S1,S2,S3, S4 гэсэн ур чадварууд уялдаж байна. "Тусламж үзүүлэгч" (PLO 1) гэсэн чадамжтай тухайн хичээлийн A1, A2, A3 гэсэн хандлагууд уялдаж байна. **Дүгнэлт:** "Эм зүйч" мэргэжилтэн бэлтгэх зарим нэгж хичээлийн хүрэх үр дүнг (CLO), "Эм зүйч" хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй (PLO) уялдуулан судлахад "Эмийн технологи" хичээлийн хүрэх үр дүн (CLO-K,S,A) Эм зүйн тусламж үзүүлэгч (PLO 1) чадамжтай, "Эмийн эдийн засаг" хичээлийн хүрэх үр дүн (CLO-K,S,A) Зохион байгуулагч (PLO 4) чадамжтай хамгийн их хамааралтай байгаа нь мэргэжлийн хичээлүүд нь хөтөлбөрийн хүрэх үр дүнд хүрч байна гэж үзэж байна.

Үндэслэл: Өнөөдөр дэлхий нийтээр эмч, эмнэлгийн мэргэжил олгох боловсролыг чанаржуулах талаар ихээхэн анхаарч байна. Дэлхий ертөнц дээр амьдарч байгаа хүн ард эрүүл мэндийн тусламж үйлчилгээг газар нутгийн онцлог, улс төр, шашин, нас хүйсээс үл хамааран ижил тэнцүүхэн хүртээх нь анагаах ухааны үндсэн зарчим юм. ДЭМБ эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэдэг эмч мэргэжилтнүүдийг бэлтгэх анагаах ухааны сургуулиудын хөтөлбөр, чанарын баталгаа, сургуулийн болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэл зэрэг асуудлуудад бүх улс орнуудын хэмжээнд онцгой анхаарал тавин ажиллах боллоо.[1]

Дээд боловсрол нь олон шинжлэх ухааны нэгдэл дундаас шинэ мэдлэгийг бүтээх, мэргэжлийн өндөр чадварыг оюутанд эзэмшүүлэх, олон талт, нарийн цогц дээд түвшний боловсрол юм. Иймд сургалтыг чанартай хүргэх сургалтын хөтөлбөрийг онцгойлон авч нухацтай ойлгох нь их, дээд сургуулийн багш нарт тун чухал бөгөөд энэхүү ойлголтоос бидний сургалтын хөтөлбөрүүдээ хэрхэн боловсруулж, хүргэхээс шалтгаалж тэр нь төгсөгчдийн чанарт шууд нөлөөлж байдаг.[2]

АШУҮИС нь Монгол Улсад эм зүйч хөтөлбөрийг анх удаа 2011 онд магадлан итгэмжлүүлсний зэрэгцээ эм зүйн тусламж, эм зүйн боловсролын олон улсын чиг хандлагад нийцүүлэн

эм зүйч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажлыг 2005 оноос анх удаа эхлүүлж эмчлүүлэгч төвтэй тусламжид чиглэсэн хөтөлбөрийг 2015 үнэлж, эмнэлзүйн эм зүйн чиглэлийн хичээл хөтөлбөрийн 28%-ийг эзэлсэн, хөтөлбөр нь олон улсын түвшинд хүрсэн, төгсөгчдөд эмчлүүлэгч төвтэй тусламж үзүүлэхэд шаардагдах чадамжийг олгож чадахуйц хөтөлбөр болсон гэж дүгнэжээ. АШУҮИС-ийн Эм зүйн сургууль эм зүйч эзэмших цогц чадамж, чадамжид суурилсан хөтөлбөрийг боловсруулах ажлыг Монгол улсдаа анх удаа 2013 оноос эхэлж, эм зүйчийн эзэмших цогц чадамжийг 2015 онд боловсруулан батлуулж, хэрэгжүүлж эхэлсэн.[3]

Олон улсад мөрдөж байгаа нийтлэг жишгээр сургалтын хөтөлбөр нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байх ба эдгээрийг товчхон тайлбарлая. Хөтөлбөрийн Боловсролын Зорилт (PEO): Хөтөлбөрийн боловсролын зорилт гэдэг нь тухайн хөтөлбөрөөр суралцаж төгсөгчид суралцаж байх үедээ олж авсан мэдлэг, ур чадвар, хандлагатаа тулгуурлан мэргэжлээрээ 4-5 жил ажилласны дараа хэрхэн хөгжиж чадамжийн хувьд ямар түвшинд хүрсэн байх ёстойг илэрхийлнэ. Хөтөлбөрийн зорилтыг их сургуулийн стратеги төлөвлөгөө, эрхэм зорилго, ажил олгогчдын судалгаа дээр үндэслэн томьёолно. Хөтөлбөрийн сургалтын үр дүнгүүд (PLO-Program Learning Outcome) нь Сургалтын үр дүнгүүд буюу Оюутан яг төгсөх үедээ юу мэддэг, юу хийж чаддаг болсон байхыг илэрхийлэх үзүүлэлтүүд юм. Хичээлийн сургалтын үр дүнгүүд (CLO-Course Learning Outcome) нь Тухайн хичээлийг судалж дуусах үед оюутан юу мэддэг, юу хийж чаддаг болохыг харуулах үзүүлэлтүүд юм.[4]

Эрүүл мэндийн чиглэлээр сургалт явуулж байгаа байгууллагын нэн тэргүүний эрхэм зорилго нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, өрсөлдөхүйц чадвартай мэргэжилтэн бэлтгэх явдал юм. Хөтөлбөрийг өөрийн нийгэм, соёлын, орчны хэрэгцээ шаардлага онцлогт нийцүүлж боловсруулах нь сургалт амжилттай хэрэгжихэд чухал ач холбогдолтой. Олон улсын эм зүйн холбоо (FIP)-ноос боловсруулсан эм зүйчийн цогц чадамжийг олон улс орны эм зүйч бэлтгэдэг их, дээд сургуулиуд өөрийн төгсгөн гаргаж буй эм зүйчийн эзэмших цогц чадамжийг тодорхойлоход ашиглаж байна. Сургалтын хөтөлбөрийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг Curriculum буюу сургалтын хөтөлбөр гэдэг нь тодорхой түвшний боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн боловсролын зорилго, зорилт, суралцахуйн үр дүн, хичээлийн агуулга, сурах, сургах арга зүй, үнэлгээний арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, тэдгээрийн хоорондын нарийн уялдаа холбоог тодорхойлсон нэгдмэл баримт бичиг юм. Сургалтын хөтөлбөрийн гарц болох хөтөлбөрийн Суралцахуйн Үр дүн гэдэг нь тухайн хөтөлбөрөөр суралцагчтөгсөх үедээ эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага үр дүнгийн нийлбэр, түүний түвшинг хэлдэг. Нэг ёсондоо оюутан төгсөх үедээ юу мэддэг, уг хийж чаддаг, аливаад хэрхэн ханддаг болсон байхыг илэрхийлэх үр дүн гэж хэлж болно.[5]

Эм зүйн боловсролын загвар, технологийг сайжруулснаар нийтийн, эмнэлэгийн, үйлдвэрийн, судалгааны аль ч ажлын байранд ажиллах эм зүйч мэргэжилтний мэргэжлийн чиг хандлага, мэдлэг, ёс зүйг багтаасан боловсролын үйлчилгээг цогц байдлаар хүргэх боломжтой юм. Эм зүйн боловсролын түвшинг дээшлүүлэхэд хүний нөөц, практик байгуулагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, эм зүйн шинжлэх ухааны байгууллагад ажилладаг судлаачид, ирээдүйд эм зүйч болох хүсэлтэй залуусын бэлтгэлд ч чухал үзүүлэлт болох юм. Иймд Монголын эм зүйн боловсролын хөгжлийн одоогийн байдалд үнэлгээ хийж, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн чадварлаг эмийн мэргэжилтнийг бэлтгэх, хөгжүүлэх чиг хандлагыг тодорхойлох судалгааг явуулах цаг нэгэнт болжээ.[6]

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн буюу хөтөлбөрөөр суралцаж төгсөх оюутны эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг сургалтын төлөвлөгөөнд байгаа ямар ямар хичээлийг судалснаар оюутанд эзэмших боломжтойг харуулсан хичээл ба суралцахуйн үр дүн хоорондын хамаарлын матрицыг хэлнэ. Үр дүнд суурилсан боловсролын тогтолцоог жинхэнэ утгаар нь хэрэгжүүлье гэвэл сургалтын төлөвлөгөөнөөс гадна сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба суралцахуйн үр дүнгүүдийн хоорондын хамаарлыг илэрхийлсэн матрицыг маш сайн боловсруулах шаардлагатай байдаг.[2]

Зорилго: “Эм зүйч” мэргэжилтэн бэлтгэх нэгж хичээлийн агуулгыг (TLO) хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй (PLO) уялдуулан үнэлэх.

Зорилт:

1. “Эм зүйч” мэргэжилтэн бэлтгэх зарим нэгж хичээлийн агуулгыг (TLO), тухайн хичээлийн хүрэх үр дүнгийн (CLO) уялдааг тодорхойлох.
2. “Эм зүйч” мэргэжилтэн бэлтгэх зарим нэгж хичээлийн хүрэх үр дүнг (CLO), “Эм зүйч” хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй (PLO) уялдуулан судлах.

Арга, аргачлал: Судалгааны зорилт 1, 2 хүрээнд: Аналитик судалгааны загвараар баримтын судалгаанд үндэслэн сургалтын хөтөлбөрийн агуулга болон хүрэх үр дүнг судласан. (Матриц 1,2)


Хэрэглэгдэхүүн: Эм зүйч мэргэжилтан бэлтгэх сургалтын төлөвлөгөөн дэх 97 хичээлээс эхний байдлаар мэргэжлийн чиглэлийн 25 хичээлээс санамсаргүйгээр 2 хичээлийг сонгон авсан.

АШУҮИС-ийг эм зүйч мэргэжлээр төгсөгч нь харилцагч, хамтрагч, зохион байгуулагч, зөвлөгч, тасралтгүй суралцагч, мэргэжилтэн байж чадах эм зүйн тусламж үзүүлэгч байна гэж тодорхойлсны дагуу “Эм зүйн цогц чадамжийн бүрдэл”-ийг ашиглан үнэлгээг хийв.

АШУҮИС-ийн Эм зүйн сургууль эм зүйч, эм найруулагчийн эзэмших цогц чадамж, чадамжид суурилсан хөтөлбөрийг боловсруулах ажлыг Монгол улсдаа анх удаа 2013 оноос эхэлж, эм зүйчийн эзэмших цогц чадамжийг 2015 онд, эм найруулагчийн эзэмших цогц чадамжийг 2018 онд боловсруулан батлуулж, хэрэгжүүлж эхэлсэн (Зураг 1).



Зураг 1. Эм зүйч мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн хүрэх үр дүн (Эм зүйч мэргэжилтэний цогц чадамж)



Зураг 2. Нэгж хичээлийн хүрэх үр дүнг (CLO), "Эм зүйч" хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй (PLO) уялдуулсан загвар.

Эм зүйч мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн хүрэх үр дүн болон Эмийн эдийн засаг, Эмийн технологийн хичээлийн төгсгөлд хүрэх үр дүнтэй мэдлэг, ур чадвар, хандлагын уялдааг гаргасан матрицын аргачлал.

Бид нэгж хичээлийн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг, сургалтын төгсгөлд хүрэх үр дүнгийн хамаарлыг тодорхойлов (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Тухайн хичээлийн агуулга ба нэгж хичээлийн хүрэх үр дүнг уялдуулсан байдал (CLO)

Үнэлгээ	Хичээлийн хүрэх үр дүн /CLO-Course Learning Outcome/			
	Хүрэх үр дүн 1 /CLO 1/	Хүрэх үр дүн 2 /CLO 2/	Хүрэх үр дүн 3 /CLO 3/	Хүрэх үр дүн 4 /CLO 4/
Лекцийн сэдэв 1	***			
Лекцийн сэдэв 2		***		
Дадлагийн сэдэв 1			***	
Дадлагийн сэдэв 2				***

Үр дүн: Эмийн эдийн засаг хичээлийн агуулга болон тухайн хичээлийн хүрэх үр дүнгийн уялдаа хамаарал. Лекцийн агуулгын хүрээнд хамгийн их хамааралтай сэдэв нь "Лекц 9" байсан тухайн хичээлийн хүрэх үр дүнгийн K3,K4,K5,S1,S4,S6,S7-тай хамааралтай байсан бол хамгийн бага хамааралтай сэдэв нь "Лекц 12", тухайн хичээлийн хүрэх үр дүнгийн K4-тэй уялдаж байлаа. Дадлагын агуулгын хүрээнд хамааралгүй сэдэв нь "Дадлага 2" байна. Дадлагын агуулгын хүрээнд хамгийн их хамааралтай сэдэв нь "Дадлага 4" байсан тухайн хичээлийн хүрэх үр дүнгийн K1,K2,S1,S2,S5,S6,S7-тай хамааралтай байсан бол хамгийн бага хамааралтай сэдэв нь "Дадлага 5, 6, 7, 8, 9, 11" тухайн хичээлийн хүрэх үр дүнгийн S3, S4, S6, S7 хамгийн бага уялдаж байлаа (Хүснэгт 2).

Хүснэгт 2. “Эмийн эдийн засаг” хичээлийн агуулга ба хичээлийн хүрэх үр дүнгийн хоорондын уялдаа хамааралыг судалсан дүн

Хичээлийн сэдэв	К1	К2	К3	К4	К5	К6	S1	S2	S3	S4	S5	S6	S7
Лекцийн сэдэв 1			*						*				
Лекцийн сэдэв 2		*					*	*					*
Лекцийн сэдэв 3		*					*	*					*
Лекцийн сэдэв 4									*				
Лекцийн сэдэв 5	*	*		*							*	*	*
Лекцийн сэдэв 6				*			*					*	
Лекцийн сэдэв 7				*						*	*	*	*
Лекцийн сэдэв 8				*			*		*			*	
Лекцийн сэдэв 9			*	*	*		*			*		*	*
Лекцийн сэдэв 10			*		*								*
Лекцийн сэдэв 11				*	*						*		*
Лекцийн сэдэв 12						*							
Дадлага 1							*	*	*				
Дадлага 2													
Дадлага 3							*	*			*		
Дадлага 4	*	*					*	*			*	*	*
Дадлага 5										*			
Дадлага 6												*	
Дадлага 7												*	
Дадлага 8												*	
Дадлага 9													*
Дадлага 10							*		*				
Дадлага 11									*				
Дадлага 12		*					*					*	

“Эм зүйч” мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн үр дүнг (PLO) “Эмийн эдийн засаг” хичээлийн хүрэх үр дүнтэй уялдуулан судлахад “Тусламж үзүүлэгч” чадамжтай тухайн хичээлийн “Мэдлэг-К” (К1,К2,К3,К4,К5,К6) сул хамааралтай, “Ур чадвар” S1, S2, S3, S4, S5, S6 сул хамааралтай байсан бол “Хандлага” түвшинд хамааралгүй байв. “Харилцагч” чадамжтай тухайн хичээлийн “Мэдлэг, Ур чадвар” түвшинд хамааралгүй, “Хандлагын” түвшинд сул хамааралтай. “Хамтрагч” чадамжтай тухайн хичээлийн “Мэдлэг, Ур чадвар” түвшинд хамааралгүй, “Хандлагын” түвшинд хүчтэй хамааралтай. “Зохион байгуулагч” мэдлэгийн түвшин хүчтэй хамааралтай, чадварын түвшин дунд хамааралтай, хандлагын түвшин сул хамааралтай. “Эрүүл мэндийн зөвлөгч” “Мэдлэг” К5 дунд хамааралтай, “Ур чадвар, Хандлага” хамааралгүй. “Суралцагч” мэдлэгийн түвшин хүчтэй хамааралтай, чадварын түвшинд хүчтэй хамааралтай, хандлагын түвшинд сул хамааралтай. “Мэргэжилтэн” “Мэдлэг, Ур чадвар” дунд хамааралтай, “Хандлагын” түвшинд хүчтэй хамааралтай байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Эм зүйч хөтөлбөрийн үр дүн болон "Эмийн эдийн засаг" хичээлийн хүрэх үр дүнгийн хоорондын уялдаа хамаарлыг судалсан дүн

PLO / CLO	Эм зүйн тусламж үзүүлэгч (PLO 1)	Харилцагч (PLO 2)	Хамтрагч (PLO 3)	Зохион байгуулагч (PLO 4)	Эрүүл мэндийн зөвлөгч (PLO 5)	Тасралттүй суралцагч (PLO 6)	Мэргэжилтэн (PLO 7)
K1	*			*		*	**
K2	*						
K3	*			***		*	*
K4	**			*		**	*
K5	*			***	**	***	*
K6	*			*		***	
S1	*			*			**
S2	**						
S3	*			*			*
S4	*						
S5	*			*			*
S6	*			*			
S7	*			**		***	*
A1		*	***				
A2		*		**			*
A3		*				*	*
A4		*	*				
A5		*	**	**		*	***

Эмийн технологи хичээлийн агуулга болон тухайн хичээлийн хүрэх үр дүнгийн уялдаа хамаарал. Лекцийн агуулгын хүрээнд хамгийн их хамааралтай сэдэв нь "Лекц 1" байсан тухайн хичээлийн хүрэх үр дүнгийн К1, А1, А2, А3-тай хамааралтай байсан бол дунд хамааралтай сэдэв нь "Лекц 7, 8, 9, 10, 11, 12", тухайн хичээлийн хүрэх үр дүнгийн К3, К4-тэй уялдаж байлаа. Дадлагын агуулгын хүрээнд хамгийн их хамааралтай сэдэв нь "Дадлага 1, 2, 3, 4, 5, 6," байсан ба тухайн хичээлийн хүрэх үр дүнгийн К1, К2, S1, S2, S3, S4, S5, A1, A2, A3-тай хамааралтай байсан бол хамгийн бага хамааралтай сэдэв нь "Дадлага 7, 8, 9" тухайн хичээлийн хүрэх үр дүнгийн К3, К4, S1, S2, S3, A1 хамгийн бага уялдаж байлаа. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. “Эмийн технологи” хичээлийн агуулга ба хичээлийн үр дүнгийн хоорондын уялдаа хамаарлыг тодорхойлсон дүн

Хичээлийн сэдэв	К1	К2	К3	К4	S1	S2	S3	S4	S5	A1	A2	A3
Лекцийн сэдэв 1	*									*	*	*
Лекцийн сэдэв 2		*								*	*	*
Лекцийн сэдэв 3		*								*	*	*
Лекцийн сэдэв 4		*								*	*	*
Лекцийн сэдэв 5		*								*	*	*
Лекцийн сэдэв 6		*								*	*	*
Лекцийн сэдэв 7			*	*								
Лекцийн сэдэв 8			*	*								
Лекцийн сэдэв 9			*	*								
Лекцийн сэдэв 10			*	*								
Лекцийн сэдэв 11			*	*								
Лекцийн сэдэв 12			*	*								
Дадлага 1	*	*			*	*	*	*	*	*	*	*
Дадлага 2	*	*			*	*	*	*	*	*	*	*
Дадлага 3	*	*			*	*	*	*	*	*	*	*
Дадлага 4	*	*			*	*	*	*	*	*	*	*
Дадлага 5	*	*			*	*	*	*	*	*	*	*
Дадлага 6	*	*			*	*	*	*	*	*	*	*
Дадлага 7			*	*	*	*	*			*		
Дадлага 8			*	*	*	*	*			*		
Дадлага 9			*	*	*	*	*			*		
Семинар 1			*	*	*	*	*			*		
Семинар 2			*	*	*	*	*					
Семинар 3			*	*	*	*	*			*		

“Эм зүйч” мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн үр дүнг “Эмийн технологи” хичээлийн хүрэх үр дүнтэй уялдуулан судлахад эм зүйч мэргэжлийн “Тусламж үзүүлэгч”, Зохион байгуулагч, Тасралтгүй суралцагч, Мэргэжилтэн гэсэн чадамжтай тухайн хичээлийн К1, К2, К3, К4 мэдлэгүүд сул хамааралтай. “Тусламж үзүүлэгч”, Харилцагч, Хамтрагч, Тасралтгүй суралцагч гэсэн чадамжтай тухайн хичээлийн S1,S2,S3, S4 гэсэн ур чадварууд уялдаж байна. “Тусламж үзүүлэгч” гэсэн чадамжтай тухайн хичээлийн А1, А2, А3 гэсэн хандлагууд уялдаж байлаа. (Хүснэгт 5)

Хүснэгт 5. Эм зүйч хөтөлбөрийн үр дүн болон "Эмийн технологи" хичээлийн хүрэх үр дүн хоорондын уялдаа хамааралыг тодорхойлсон дүн

CLO \ PLO	Эм зүйн тусламж үзүүлэгч (PLO 1)	Харилцагч (PLO 2)	Хамтрагч (PLO 3)	Зохион байгуулагч (PLO 4)	Эрүүл мэндийн зөвлөгч (PLO 5)	Тасралтгүй суралцагч (PLO 6)	Мэргэжилтэн (PLO 7)
K1	*			*		*	*
K2	*			*		*	*
K3	*			*			*
K4	*			*			*
S1	*	*					
S2	*	*				*	
S3	*	*				*	
S4	*	**	**			*	
S5	*						
A1	*						
A2	*						
A3	*						

Хэлцэмж: Бид Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эм зүйч мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн үр дүнг (цогц чадамж) зарим нэгж хичээлийн хөтөлбөрийн хүрэх дүн болон хичээлийн агуулгатай уялдуулан үнэллээ.

Бид судалгааны баримт болох Эм зүйч мэргэжилтэн бэлтгэх цогц цадамж, мэргэшүүлэх чиглэлийн нэгж хичээлийн хөтөлбөрүүдийг бэлдэж хөтөлбөрийн үр дүн, суралцахуйн үр дүн болон хичээлийн агуулгын уялдааг Блумын танин мэдэхүйг тодорхойлох үгээр уялдуулж нэгж хичээлийн хөтөлбөр болон хөтөлбөрийн хүрэх үр дүнг үнэлсэн нь Үр дүнд суурилсан эм зүйн шинжлэх ухааны сургалтын хөтөлбөр боловсруулах нь: Гурвалжингийн аргад суурилсан Khor P нарийн судалгаатай Блумын танин мэдэхүйг тодорхойлох үгээр уялдуулсан нь харьцангүй дүйж байна.[7]

2020-2021 онд Саудын арабын Prince Sultan их сургууль нь оюутнууддаа дээд зэргийн чанартай боловсрол олгохыг эрмэлздэг. Иймээс оюутны сурлагын үр дүнг үнэлэх нь мэдээжийн хэрэг үндсэн болон байнгын үйл ажиллагаа болж, багш, удирдлагуудыг оюутнууддаа бидний хүсч буй үр дүн, оюутны сургалтын үр дүнд хүрэхэд дэмжлэг үзүүлэх боловсролын туршлагын талаар бодоход түлхэц өгдөг. Энэхүү баримт бичиг нь оюутны сурлагын амжилтыг үнэлэх зорилго, үйл явцын ерөнхий тоймыг өгөх, үнэлгээний үр дүнг сурагчдын сурлагын сайжруулах зорилгоор хөтөлбөрийн өөрчлөлт хийхэд ашиглах зорилготой юм.[8]

Америкийн Эм зүйн коллежийн нийгэмлэгээс Эмийн эмчилгээний курсын үр дүнг сэдвийн үр дүнтэй уялдуулж байгааг үнэлэх нь Numa Vera нарийн судалгаатай Хичээл тус бүрд хүрэх үр дүнгүүд өөр байсан бөгөөд хичээлийн хүрэх үр дүн болон сэдвийн агуулга хооронд уялдуулах өргөн ялгаа олдсон. Тодорхойлсон асуудлууд нь илүүц үйл үгийн хэрэглээ, танин мэдэхүйн түвшин, үр дүн бүрт шингэсэн мэдлэгийн төрлүүдийн зохицол, тэнцвэрт байдал хангалтгүй байсан нь дүйж байна.[9]

Нэгж хичээлийн хүрэх үр дүн тухайн хичээлийн онцлогоос хамаарч хөтөлбөрийн хүрэх үртэй уялдаж байгаа нь Эм зүйч хөтөлбөрөөр суралцагч нь эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшдэг болох нь Хичээлийн сургалтын хөтөлбөрийг хэмжих: Mohsen K нарийн судалгаатай харьцангүй дүйж байна.[10]

Дүгнэлт:

1. "Эм зүйч" мэргэжилтэн бэлтгэх зарим нэгж хичээлийн агуулгыг (TLO), тухайн хичээлийн хүрэх үр дүнтэй (CLO) уялдуулан тодорхойлоход лекцийн агуулга тухайн хичээлийн хүрэх үр дүнгийн мэдлэгтэй (К) илүү уялдаж байсан бол дадлага хичээлийн агуулга тухайн хичээлийн хүрэх үр дүнгийн чадвартай (S) болон хандлагатай илүү их уялдаж байгаа нь энэ хичээлээр төгсөгч мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшиж чадаж байна.
2. "Эм зүйч" мэргэжилтэн бэлтгэх зарим нэгж хичээлийн хүрэх үр дүнг (CLO), "Эм зүйч" хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй (PLO) уялдуулан судлахад "Эмийн технологи" хичээлийн хүрэх үр дүн (CLO-K,S,A) Эм зүйн тусламж үзүүлэгч (PLO 1) чадамжтай, "Эмийн эдийн засаг" хичээлийн хүрэх үр дүн (CLO-K,S,A) Зохион байгуулагч / PLO 4/ чадамжтай хамгийн их хамааралтай байгаа нь мэргэшүүлэх хичээл нь мэдлэг, ур чадвар, хандлагыг мөн эзэмшүүлж чадаж байна.

Ном зүй:

1. *Ц.Лхагвасүрэн, Н.Сүмбэрзул, Д.Цэрэндагва, Б.Оюунгоо, Д.Отгонбаяр. Анагаах ухааны боловсрол судлал. УБ хот 2018, хуудас 21.*
2. *Г.Орхонбаяр. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн тухай ойлголт. Монгол улс, УБ хот 2018, хуудас 1-2.*
3. *С.Пүрэвсүрэн, Эм зүйн салбарын хөгжилд эм зүйн боловсролын гүйцэтгэсэн үүрэг, Эм зүйн сэтгүүл №4 (79), хуудас 311.*
4. *Н.Эрдэнэхүү, Д.Түмэнболд, Д.Ариунболор. Үр дүнд суурилсан боловсролын хөтөлбөрт үнэлгээ хийх жишиг арга зүй. УБ хот 2019, хуудас 2-4.*
5. *Д.Энхжаргал. Монголын эм зүйн салбарын боловсролын асуудалд. Анагаах ухааны боловсрол судлал. 2013:х.39.*
6. *АШУҮИС. Эм зүйч мэргэжилтний цогц чадамж. УБ хот 2016, хуудас*
7. *Khor Poh Yen, Mahendran Sekar, Mohammed Tahir Ansari. Developing an Outcome-Based Pharmaceutical Science Curriculum: an Evaluation Based on Triangulation Method, Indian Journal of Pharmaceutical Education and Research | Vol 50 | Issue 4 | Oct-Dec, 2016, pages 535-538.*
8. *https://www.psu.edu.sa/psu/articles/2021/11/11/assessment-handbook-11-november-2021_1636630683.pdfAldemir C, Gülcan Y. Student satisfaction in higher education. Higher education management and policy. 2004;16(2):109-122.*
9. *Numa Vera, Louise Young, Linda Sweet. Assessing the Alignment of Pharmacotherapeutics Course Outcomes With Topic Outcomes 2019 Volume 83(3);*
10. *Mohsen Keshavarz, Measuring course learning outcomes, 2011 Vol. 4 No. 4 pages 4.*

Unit curriculum evaluation of pharmacist training course

Bilguun B[1], Ankhzaya Z[3], Shinezaya D[1], Oyungoo B[2], Davaadagva D[1]

[1]Department of Pharmaceutical Technology, School of Pharmacy, MNUMS
[2]School of Nursing, MNUMS
[3]General hospital for state special servant
E-mail: Bilguun.ba@mnums.edu.mn, Tel: +976-99804015

Background: Our research focuses on developing a correlation matrix that illustrates the relationship between courses and the program's learning outcomes. These outcomes encompass the knowledge, skills, and attitudes expected of graduating students.

Aim: Assess the alignment with Program Outcomes (PLO) to attain Unit Learning Outcomes (CLO) for the 'Pharmacist' Development Unit.

Materials and Methods: Objectives 1 and 2: Employ an analytical research method grounded in evidence-based learning content and outcomes assessment. /Matrix 1,2/ Materials: Two courses were randomly chosen from a pool of 97 courses outlined in the pharmacist training program. Based on the perspective that a graduate from ASUU as a pharmacist serves as a customer-centric pharmaceutical care provider, capable of collaboration and adept at studying tests, an evaluation of the utilization of the 'Complex Pharmaceutical Competence Structure' was conducted.

Results: The correlation between outcomes of the 'Pharmacist' specialization training and those of the 'Pharmaceutical Economics and Pharmaceutical Technology' course is robustly associated with Course A and less so with Course B. Topics covered in the 'Economics and Pharmaceutical Technology' and 'Pharmaceutical Economics and Pharmaceutical Technology' courses are addressed through lectures, practicals, seminars, and homework. However, their alignment with the knowledge, skills, and attitudes is somewhat loosely connected.

Conclusions:

1. The outcomes of the "Pharmacist" specialist training program have overlooked the essential knowledge, skills, and attitudes necessary for students in certain professional courses. Specifically, there's a noticeable gap in the development of learning outcomes within the "Pharmaceutical Economics and Pharmaceutical Technology" course.
2. Subject matter covered in specialized courses aligns moderately to strongly with the objectives of the "Pharmacist" specialist training program, showcasing a correlation in the achieved results.

Keywords: Program, Subject matter, Matric, Pharmacist